



СОЁЛЫН ЯАМ





МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ
КИНО УРЛАГИЙН
ЗӨВЛӨЛ

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНД ТӨСӨЛ МЭДҮҮЛЭГЧИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

(ТӨСЛИЙН ТӨРӨЛ: КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
САНХҮҮЖИЛТ)

Төслийн төрөл: КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ САНХҮҮЖИЛТ

№1	НЭВТРЭЛТ
1.1	<p>Кино урлагийг дэмжих санд төсөл илгээхийн тулд www.kuds.filmmongolia.gov.mn хаягт хандан хувь хүн эсвэл албан байгууллагаар бүртгүүлэн тус системд нэвтэрч төсөл мэдүүлнэ.</p> <p>2. Кино урлагийг дэмжих сангийн системд бүртгэлээр нэвтрэн орсны дараа “КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ САНХҮҮЖИЛТ” гэсэн формыг сонгож орно.</p> <div data-bbox="643 642 1075 852" style="text-align: center;">  <p>Кино наадам болон сургалт зохион байгуулах санхүүжилт</p> </div> <p>3. “КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ САНХҮҮЖИЛТ” форм руу орж “+ Нэмэх” гэсэн товчийг дарснаар төслийн хүсэлт илгээх талбарууд гарч ирнэ.</p> <div data-bbox="513 1003 1247 1146" style="text-align: center;">  <p>КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛ</p> <p>+ Нэмэх</p> </div>
№2	“ТӨСЛИЙН ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага
	<p>Кино наадам болон сургалт зохион байгуулах санхүүжилт форумын “Төслийн хүсэлт гаргагчийн мэдээлэл” талбарт дараах 3 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Өргөдөл / Албан бичиг • Иргэний үнэмлэхийн хуулбар / Байгууллагын гэрчилгээний хуулбар (<i>Та хувь хүнээр төсөл мэдүүл буй тохиолдолд өөрийн иргэний үнэмлэхийн цахим хуулбарыг файлаар хавсаргана. Хэрэв албан байгууллагаар мэдүүлж буй тохиолдолд тухайн байгууллагын гэрчилгээг хавсаргана.</i>) • Гадаад хэлний түвшин тодорхойлох бичиг баримт (<i>гадаад хэл дээрх баримт бичиг бол орчуулгын хамт ирүүлэх</i>)
2.1	<p style="text-align: center;">ӨРГӨДӨЛ / АЛБАН БИЧИГ</p> <p>Тухайн төсөл, арга хэмжээ нь “Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкнийг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн</p>

	<p>төлөх, хяналт тавих журам” -ын 1.4-д заасан зөрчилгүй. Кино бүтээх төсөл нь тус журмын 2.2.3, 2.2.4 -д заасан чиглэлүүдийн нэг болон түүнээс дээш зүйлд нийцэж буйг өргөдөлдөө сайтар тусгасан байна. Мөн төслийн хэрэгжүүлэлтийн аль үе шат, үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг шаардлагатай байгааг бичиж, Кино урлагийг дэмжих сангаас хүсэж буй санхүүжилтийн хэмжээ, тус үнийн дүн нь төслийн нийт төсвийн хэдэн хувь болохыг дурдсан байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо: 150-300</p>
2.2	<p>ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН ХУУЛБАР / БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР Та хувь хүнээр төсөл мэдүүл буй тохиолдолд өөрийн иргэний үнэмлэхийн цахим хуулбарыг файлаар хавсаргана. Хэрэв албан байгууллагаар мэдүүлж буй тохиолдолд тухайн байгууллагын гэрчилгээний хуулбар (нүүр болон ар тал)-ыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
2.3	<p>ГАДААД ХЭЛНИЙ ТҮВШИН ТОДОРХОЙЛОХ БИЧИГ БАРИМТ Олон улсын кино наадам болон кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулагчдын гадаад хэлний мэдлэгийг тодорхойлох баримт бичгийг хавсаргана. <i>(Хэрэв гадаад хэл дээр бол орчуулгын хамт илгээнэ.)</i></p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
№3	<p>“ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага</p>
	<p>Кино наадам болон сургалт зохион байгуулах санхүүжилт форумын “Төслийн ерөнхий мэдээлэл” талбарт дараах 8 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Кино наадам / сургалт зохион байгуулж байсан туршлагын мэдээлэл • Кино наадам / сургалтын хөтөлбөр • Кино наадам зохион байгуулагчид / сургалтын багшлах бүрэлдхүүний туршлагын мэдээлэл • Гадаад иргэн кино наадам / сургалтын үйл ажиллагаанд оролцон ажиллах эсэх <ol style="list-style-type: none"> I. Гадаад мэргэжилтний харъяа улс, албан байгууллага, ажлын туршлагыг багтаасан танилцуулга II. Гадаад мэргэжилтний ажлын төлөвлөгөө • Кино наадамд оролцогчдын мэдээлэл • Төслийн хүрэх үр дүнгийн талаарх баримт бичиг • Бусад <i>(Кино наадам / сургалт зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны талаарх нэмэлт мэдээлэл)</i>



3.1	<p align="center">КИНО НААДАМ / СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙСАН ТУРШЛАГЫН МЭДЭЭЛЭЛ</p> <p>Олон улсын кино наадам / кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалт зохион байгуулж байсан туршлага, өмнөх ОУ-ын наадам/ сургалтын талаарх мэдээллийг илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.2	<p align="center">КИНО НААДАМ / СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР</p> <p>Олон улсын кино наадам / кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалтын батлагдсан албан ёсны хөтөлбөрийг илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.3	<p align="center">КИНО НААДАМ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД / СУРГАЛТЫН БАГШЛАХ БҮРЭЛДХҮҮНИЙ ТУРШЛАГЫН МЭДЭЭЛЭЛ</p> <p>Олон улсын кино наадам / кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах баг бүрэлдэхүүний өмнө нь ижил төстэй төсөл, хөтөлбөрт ажилласан туршлагын мэдээллийг илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.4	<p align="center">ГАДААД ИРГЭН КИНО НААДАМ / СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОН АЖИЛЛАХ ЭСЭХ</p> <p>Хэрэв олон улсын кино наадам / кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалтын үйл ажиллагаанд оролцон ажиллах гадаадын иргэн байгаа бол ТИЙМ сонголтыг сонгож тухайн иргэний мэдээллийг хавсарган илгээнэ. Тус зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцож буй гадаадын иргэн байхгүй бол ҮГҮЙ сонголтыг хийнэ. ТИЙМ гэсэн сонголтыг сонгосон бол дараах 2 файлыг хавсаргана.</p> <ul style="list-style-type: none"> • <i>Гадаад мэргэжилтний харьяа улс, албан байгууллага, ажлын туршлагыг багтаасан танилцуулга</i> <p>ОУ-ын кино наадам / кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалтад ажиллах гадаад мэргэжилтний харьяа улс, албан байгууллага, ажлын туршлагыг багтаасан танилцуулга мэдээллийг илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p> <ul style="list-style-type: none"> • <i>Гадаад мэргэжилтний ажлын төлөвлөгөө</i> <p>Гадаад мэргэжилтний тухайн үйл ажиллагааны хүрээнд ажиллах ажлын төлөвлөгөөг хавсарган илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>



3.5	<p align="center">КИНО НААДАМД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ</p> <p>Олон улсын кино наадам / кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалтын хамрах хүрээ, оролцогчдод тавигдах нийтлэг шаардлагын талаар бичнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.6	<p align="center">ТӨСЛИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ БАРИМТ БИЧИГ</p> <p>Тухайн төсөл хэрэгжсэнээр монгол киноны урлагийн салбарт оруулах хувь нэмэр, төслийн хүрээнд кино урлагийн уран бүтээлчид болон дагалдах салбарын хэдэн ажилчдыг дадлагажуулах, гэрээт ажлаар хангах, олон улсын кино наадам / сургалтын хүрээнд уран бүтээлчдийн ур чадварыг хэрхэн хөгжүүлэх зэрэг төслийг хэрэгжүүлснээр гарах нийгэм, эдийн засгийн үр нөлөөг бичнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо: 150-300</p>
3.7	<p align="center">БУСАД</p> <p>Кино наадам / кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалт зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны талаарх нэмэлт мэдээллийг хавсарган илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
№4	<p align="center">“ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага</p>
	<p>Кино наадам болон сургалт зохион байгуулах форумын “Төслийн санхүүжилтийн мэдээлэл” талбарт дараах 1 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө нотолгооны баримт бичиг
4.1	<p align="center">ХӨРӨНГӨ НОТӨЛГӨОНЫ БАРИМТ БИЧИГ</p> <p>“Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкийг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журам”-ын 4.7-д заасны дагуу тухайн төслийн нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг төсөл мэдүүлэгч шийдвэрлэсэн байх шаардлагатай тул тухайн хувь хэмжээг нотлох 6 сарын дансны хуулга аль эсвэл, албажсан баримт бичиг, гэрээг хавсарган ирүүлнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>

ЖИЧ :

1. “КИНО НААДАМ БОЛОН СУРГАЛТ ЗОХИН БАЙГУУЛАХ САНХҮҮЖИЛТ” -ийн төслийн мэдүүлэгт хавсаргах файлуудад энэхүү зөвлөмжид заасан холбогдох агуулгыг боловсруулан бэлтгэж, стандартыг мөрдөж шаардлага хангасан, үнэн бодит мэдээлэлтэй материал илгээх ёстойг анхаарна уу.


2. Дараах талбаруудыг бөглөхдөө + тэмдэг дээр дарж гарч ирэх хүснэгтэд холбогдох мэдээллийг бичнэ. Үүнд:

- КИНО НААДАМ / СУРГАЛТЫГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГАА ЭСЭХ


Хэрэв олон улсын кино наадам / кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх сургалтыг хамтран зохион байгуулж буй байгууллага байгаа бол ТИЙМ сонголтыг сонгож тухайн байгууллагын мэдээллийг хүснэгтийн дагуу өгөгдлийг бөглөн илгээнэ. Хамтран зохион байгуулагч байхгүй бол ҮГҮЙ сонголтыг хийнэ.

- “Төслийн санхүүжилтийн мэдээлэл” талбарын “Санхүүгийн задаргаа” хэсэг болно.

Жишээ нь:

Санхүүгийн задаргаа + 

Санхүүгийн задаргаа +

ДД	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ	ТАЙЛБАР	...
1				

3. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВ

Төслийн мэдүүлэг бөглөх явцад “Баталгаажуулалтын төлөв” хэсгийн “Хадгалаад засварлах / Update” төлөвийг сонгон “Хадгалах” товчийг дарж системд оруулсан мэдээллээ хадгална. Мэдүүлгийн бүх тайлбарыг бөглөж дууссаны дараа тухайн хэсгийн “Баталгаажуулж илгээх/ Submit” төлөвийг сонгож “Хадгалах” товчийг дарж төслөө илгээнэ.

Баталгаажуулж илгээх / Submit

Хадгалаад засварлах / Update

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ